

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ

МАГСАР НАНДИНЧИМЭГ

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Е-09180103 Эрүүл мэндийн бодлого, удирдлага

Нийгмийн эрүүл мэндийн магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл

Улаанбаатар
2016

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ

МАГСАР НАНДИНЧИМЭГ

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

АУ-ны доктор О.Болорсайхан

Эрдэм шинжилгээний ажлын зөвлөх:

АУ-ны доктор Л.Мөнх-Эрдэнэ

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

БУ-ны доктор Д.Түмэндэмбэрэл

Улаанбаатар

2016

ТОВЧ ХУРААНГУЙ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Үндэслэл: Үндэсний төрийн бус байгууллагуудийн (ТББ) хөгжлийн төлөвшлийг судалсан судалгаагаар ТББ-ын дотоод удирдлага, хүний нөөцийн хөгжил сул, гадаад хамтын ажиллагаа, түншлэл хязгаарагдмал мөн санхүүгийн гадаад эх үүсвэрээс хараат байдалтай зэрэг нь үндэсний ТББ хувьд хөгжлийн гол саад, бэрхшээл болж байна. Ардчиллын Боловсрол Төвийн гүйцэтгэсэн “ТББ-уудын лавлагаа” судалгаанд нийт судалгаанд хамрагдсан ТББ-ын 59.9 % олон улсын тусламж, 27.9% өөрсдийн үйл ажиллагаа орлого, 12.6 % бусад хандив, дэмжлэг гэсэн эх үүсвэрээс бүрджээ.

Ардчилсан нийгэмд ТББ-ыг төрийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтэнд хяналтанд тавих онцгой эрх, үүрэг бүхий “Хоточ нохой” (Watchdog) субъект ба бизнес, арилжааны ашиг сонирхлоос илүүтэй иргэдийн ашиг сонирхлыг төлөө үйл ажиллагаагаа чиглүүлэх байгууллага хэмээн тодорхойлсон. Гэвч энэ үүргээ бодитойгоор гүйцэтгэж байгаа нийгэмд танигдсан, чадварлаг, нөлөө бүхий ТББ-ын тоо цөөн төдийгүй энэ ТББ-ын ХШҮ-г гүйцэтгэхтэй холбоотой нөөц, чадвар, оролцооны байдал нь тодорхойгүй, мэдээлэл хомс байсан нь бидний судалгаа хийх үндэслэл боллоо.

Зорилго: Эрүүл мэндийн чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч ТББ-ын эрүүл мэндийн салбарын бодлого, үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэж буй өнөөгийн байдлыг үнэлэх

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн ба арга зүй: Эрүүл мэндийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч, эрүүл мэндийн төсөл, хөтөлбөрийн ХШҮ хэрэгжүүлэгч нийт 80 ТББ-ыг хамруулан судаллаа. Мэдээлэл цуглуулахдаа “Ази, Номхон далай, Америкийн Эрүүл Мэндийн Форум” олон улсын байгууллагын C4H (Capacity for Health) цахим мэдээллийн сан төслийн хүрээнд боловсруулсан ЭМ-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-ын ХШҮ-ний чадавх, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлдэг асуумж, “Цогц чадавхийн хөгжлийн үнэлгээ”-г (Integrated Competency Development) “Хяналт, үнэлгээний чиглэлээр ажилтны мэдлэг, ур чадварыг үнэлэх нь” дэд хэсгийг авч ашигласан. Чанарын судалгааны арга болох баримт бичигт шинжилгээ, ганцаарчилсан ярилцлагыг ашиглан мэдээлэл цуглуулав. Мэдээллийн үр дүнгийн боловсруулалтыг хийхдээ тоон мэдээллийг Excel, SPSS-17

программыг ашиглан анхан шатны боловсруулалт хийж үр дүнг гаргасан. Баримт, бичгийн судалгааны хүрээнд цуглуулсан мэдээлэлд анализ хийн нэгтгэн дүгнэв.

Судалгааны үр дүн: ТББ-ын 25 хувь нь байгууллагуудын дотоодод болон салбарын бодлого, үйл ажиллагааны хүрээнд, ХШҮ-ний чиглэлээр тодорхой хэмжээний үйл ажиллагаа хэрэгжүүлдэг байгууллагууд байна. Тус байгууллагуудад эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн буюу мэргэжилтэй боловсон хүчний тоо харьцангуй цөөн (6%) буюу судалгаанд оролцсон ТББ-ын дийлэнх буюу 51 хувь нь эрүүл мэндийн чиглэлийн 1-3 ажилтантай байна. ТББ-ын 21.5 хувь нь ХШҮ хариуцсан ажилтантай төдийгүй энэ чиглэлээр ажиллах боломжтой туршлага бүхий ажилтан (13.75%), гэрээт зөвлөхтэй (7.5%) байна. ТББ-ын ХШҮ хэрэгжүүлэх чадавхийн байдал хангалтгүй, судалгаа, үнэлгээний ажил эрхэлсэн туршлагагүй (78,75%) нөгөө талаар ТББ-ууд өөрсдөө бүрэн чадавхижаагүй байгаа нь энэ чиглэлийн нээлттэй өрсөлдөөнд оролцох, шалгарах, шалгуур үзүүлэлтийг хангахад хүндрэлтэй (82,6%) байна. Үндэсний хэмжээнд хэрэгждэг эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэгч нь төрийн байгууллагууд байдаг төдийгүй хэрэгжилтийн явцын, дунд шатны болон хөтөлбөрийн нэгдсэн үр дүнгийн үнэлгээг хэрэгжүүлэгч нь ч мөн ихэнхдээ төрийн байгууллагууд байна.

Судалгааны дүгнэлт:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлдэг ТББ-д ХШҮ-ний чиглэлээр бие даасан буюу үндсэн чиглэлээ болгон ажиллах нөөц, чадавхи нь хангалттай бүрдээгүй (81,25%) мөн ХШҮ-г хэрэгжүүлэхэд хамгийн ихээр мэргэшсэн хүний нөөцийн (72.9%) асуудал тулгамдаж байна.
2. Эрүүл мэндийн салбарын бодлого, шийдвэр гаргах үйл ажиллагаанд хөндлөнгийн байр сууринаас хяналт хэрэгжүүлэх ТББ-ын үүрэг, оролцоог идэвхижүүлсэн дэмжлэгт орчин хангалттай хэмжээнд бүрдээгүй (44.2%) байна. Тэр дундаа салбарын бодлого, үйл ажиллагааны хүрээнд ХШҮ хэрэгжүүлэх нээлттэй тендэр өрсөлдөөн, захиалгат төсөл хангалтгүй (71.25%) байдаг төдийгүй ТББ-ын хэрэгжүүлсэн ХШҮ-ний үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй байдал (22.5%) ч тулгарч байна.
3. Цаашид үндэсний ТББ-ын тогтвортой байдал, ХШҮ-ний чадавхийг сайжруулах зорилгын үүднээс төр болон ТББ аль аль нь зайлшгүй анхаарах шаардлагатай нь ажиглагдлаа.

Түлхүүр үг: ТББ, ХШҮ, чадавхи, нөөц, оролцоо

ABSTRACT

ANALYSIS OF CURRENT SITUATION OF MONITORING AND EVALUATION OF LOCAL NGO IMPLEMENTING HEALTH PROJECTS AND PROGRAMMES

Background: Despite the huge amount of resources provided to the local NGOs to implement health related programmes and projects and despite the fact that these projects play a big role in the prevention and fight against communicable and non communicable diseases in the community it is not clear how effectively the monitoring and evaluation is done on these projects implemented by state health institution and local Health NGOs. The study aimed to assess priorities, preparedness, practices, needs challenges relating to M&E in local NGOs implementing health projects and programmes in Mongolia (Health NGO). The study aimed to assess the current situation of local NGO`s capacity and challenges towards monitoring and evaluation and their role in monitoring and evaluation of health policy and program implementation.

Purpose: Assess the capacity/resource towards internal and external monitoring and evaluation of local NGO implementing health projects and programs.

Materials and methods: Data for the study was collected using the qualitative (key informant interview and document review) and quantitative -descriptive survey method where a questionnaire was administered to project managers and monitoring and evaluation officials of the NGOs. 80 local NGOs has involved in this study as a respondents.

Results: Among targeted NGOs , there are no special unit designated to carry out M&E activities and only 21.25 % of total NGO has officer who is in charge of M&E activities. Most of the NGOs (76.25%) faced financial challenges in carrying out monitoring and evaluation of the projects and these challenges made it hard for the NGOs to effectively monitor and evaluate the projects they implemented. 74.2 % of NGOs assessed themselves that their M&E skill and expertise is limited to conduct external and internal M&E. There are some general act regulating NGO role in state policy implementation has been approved by government key officials. But there are very limited participation of local NGOs in monitoring and evaluation of health policy and program. The willingness and readiness of the Ministry of Health to recognize and

accept local NGOs as agents for monitoring and evaluation of health policy and programmes services needs to be increased.

Conclusion: It is evident from the resultant data, discussion and analysis that the local Health NGO has a big role to play in M&E of health project and programmes but have done so minimally due to the problems and challenges facing them both as an institution limited capacity and environment from the official partner of health sector. (such as inadequate finances, lack of expertise, limited support from government and multi-donor reporting requirements. As an institution the MoH cannot fully achieve M&E of national program on health on its own and to be able to overcome some of its challenges, the intervention and cooperation of other actors like the local non-governmental organizations and local researchers is necessary.

The study made some recommendations in order to mitigate the challenges faced by the NGOs.

Key words: *Non Government Organization, Monitoring and Evaluation, Programme and Project, capacity, resource*

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	7
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	8
БҮЛЭГ 1. УДИРТГАЛ.....	8
1.1 Судалгааны ажлын үндэслэл.....	8
1.2 Судалгааны ажлын зорилго, зорилт.....	10
1.3 Судалгааны ажлын шинэлэг тал.....	10
1.4 Судалгааны ажлын практик ач холбогдол.....	10
1.5 Судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн байдал.....	10
1.6 Судалгааны ажлыг хэвлүүлсэн байдал.....	11
1.7 Судалгааны ёс зүйн асуудал.....	11
1.8 Диссертацийн бүтэц, хэмжээ.....	12
БҮЛЭГ 2. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ.....	13
2.1 ТББ-ын үүсэл, хөгжил, үндсэн чиг үүрэг.....	13
2.2 Төрийн Байгууллагад хийгдэж буй хяналт, үнэлгээний төрлүүд.....	15
2.3 Төсөл, хөтөлбөрийн тухай ойлголт.....	17
2.4 Хяналт шинжилгээ, үнэлгээ үүсэж хөгжсөн түүх.....	17
2.5 Хяналт шинжилгээ, үнэлгээний тухай ойлголт	18
2.5.1 Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ.....	20
2.5.2 Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн үнэлгээ.....	21
2.5.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээний ялгаатай талууд.....	22
2.6 ХШҮ-г гүйцэтгэх чадавхийн тухай ойлголт.....	23
2.7 ХШҮ-ний мэргэшсэн ажилтан/мэргэжилтэн гэж хэнийг хэлэх вэ?.....	24
2.8 Төсөл, хөтөлбөрийн ажилтнуудын суралцах буюу чадавхжих явц.....	30
2.9 ТББ-ийн ХШҮ-ний чиглэлээр хэрэгжсэн томоохон төсөл, хөтөлбөрүүд..	32
2.10 ЭМ-ийн салбар дах ТББ-ын хамтын ажиллагааны туршлага.....	34
БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ.....	35
3.1 Судалгааны загвар.....	35
3.2 Судалгааны хүрээ ба түүвэр.....	35
3.3 Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн.....	37
3.4 Үр дүнгийн боловсруулалт.....	41
БҮЛЭГ 4. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН.....	42
4.1 Эрүүл мэндийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч ТББ-ын ХШҮ-г гүйцэтгэх	42

нөөц, чадавх

4.1.1 ТББ-уудын тархалтын байдал.....	42
4.1.2 ТББ-ын ХШҮ хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц бүрдсэн.....	43
4.1.3 ТББ-ын хүний нөөцийн ерөнхий үзүүлэлтийн дүн.....	45
4.1.4 ТББ-ын болон санхүүгийн материаллаг нөөц бүрдсэн байдал.....	47
4.1.5 ТББ-ын ажилтнуудын ХШҮ хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварын байдал.....	49
4.1.6 ТББ-ын ХШҮ-ний бодлого төлөвлөлт, хэрэгжилтийн байдал.....	51
4.2. Эрүүл мэндийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг ТББ-ын ХШҮ-ний ажил гүйцэтгэхэд тулгамдаж буй асуудал, оролцоо	53
4.2.1 ТББ-ын ХШҮ хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл	53
4.2.2 ЭМ-ийн салбарт хэрэгжсэн Үндэсний хөтөлбөрт хөндлөнгийн ХШҮ хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн тойм.....	57
4.2.3 Бусад салбарын бодлого, үйл ажиллагаа болон ТББ-ын ХШҮ-ний оролцооны байдал.....	58
БҮЛЭГ 5. ХЭЛЦЭМЖ.....	62
БҮЛЭГ 6. ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ.....	68
НОМЗҮЙ.....	71
ТАЛАРХАЛ.....	76
ХАВСРАЛТ.....	77